

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2026 оны 03 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Аж ахуйн нэгж
11. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСАГ 2025 ОНД

ДНБ-ий өсөлт

(2025 он)

6.8 хувь

Гадаад валютын нөөц

(2025 он)

7,005 сая \$

Инфляц

(2025 оны 12 дугаар сар)

7.5 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2025 оны 12 дугаар сар)

-1,232 тэрбум ₮

Экспорт

(2025 он)

15.7 тэрбум \$

Импорт

(2025 он)

11.3 тэрбум \$

ГШХО

(2025 он)

3.8 тэрбум \$

Зээлийн хүү

(2025 оны 12 дугаар сар)

17.2 хувь

Ажиллагчдын тоо

(2025 оны 4 дүгээр улирал)

1.38 сая

*IV улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 62.3 хувь байна.

Бодит цалин

(2024 оны 4 дүгээр улирал)

2.4 сая

*ХҮИ 2023=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2025 оны 4 дүгээр улирал)

116.8 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2025 оны 4 дүгээр улирал)

5.0 хувь

ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД – 2026.03

ДНБ-ий өсөлт

(2025 он)

6.8 хувь

Гадаад валютын нөөц

(2026 оны 3 дугаар сар)

7,188 сая \$

Инфляц

(2026 оны 3 дугаар сар)

7.4 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2026 оны 3 дугаар сар)

-1,361 тэрбум ₮

Экспорт

(2026 оны 3 дугаар сар)

4.9 тэрбум \$

Импорт

(2026 оны 3 дугаар сар)

2.5 тэрбум \$

ГШХО

(2025 он)

3.8 тэрбум \$

Зээлийн хүү

(2026 оны 3 дугаар сар)

17.6 хувь

Ажиллагчдын тоо

(2025 оны 4 дүгээр улирал)

1.38 сая

*IV улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 62.3 хувь байна.

Бодит цалин

(2026 оны 3 сар)

2.3 сая

*ХҮИ 2023=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2026 оны 1 дүгээр улирал)

117.3 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2025 оны 4 дүгээр улирал)


5.0 хувь



Эдийн засгийн өсөлт 2025 онд 6.8 хувь хүрч, сэргэлээ. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл эрчимжиж нийт өсөлтийг дэмжсэн байна. Хөдөө аж ахуй, боловсруулах, эрчим хүч, барилгын салбар өсөлтийг дэмжсэн бол худалдааны салбар агшиж өсөлтийг сааруулсан хэвээр байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


(салбараар)

ДНБ	2024.IV	2025.IV
		5.1
Хөдөө аж ахуй	-28.7	33.2
Уул уурхай	10.8	10.6
Боловсруулах	-4.2	10.0
Цахилгаан, ус	4.8	9.4
Барилга	14.0	15.9
Худалдаа	11.9	-4.6
Тээвэр	16.4	4.8
Мэдээлэл, холбоо	17.4	7.2
Үйлчилгээний бусад	8.9	3.5
Цэвэр татвар	14.7	0.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УУЛ УУРХАЙ


(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨДӨӨ АЖ АХУЙ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2025 онд **6.8 хувиар өслөө.**
- Анхдагч салбар: Хөдөө аж ахуй 33.2 хувиар тэлж, өсөлтийн 2.9 нэгж хувийг, уул уурхай 10.6 хувиар тэлж, өсөлтийн 1.4 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 11.8 хувиар өсөж өсөлтийн 1.5 нэгж хувийг бүрдүүлэв.
- Үйлчилгээний салбар /худалдаанаас бусад үйлчилгээний салбарууд өссөн/ 2.7 хувиар өсөж, өсөлтийн 1.0 хувийг бүрдүүллээ.
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 0.3 хувиар өсөж, өсөлтийг 0.04 нэгж хувиар дэмжив.

- Эдийн засгийн өсөлтийг хөдөө аж ахуйн салбар болон уул уурхайн салбарын өсөлт голлон дэмжсэн бол худалдааны салбар агшиж өсөлтийг саарууллаа.
- Боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж, тээврийн салбарын үйлдвэрлэл нэмэгдэж өсөлтөд эергээр нөлөөллөө.
- Хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа буурсны голлох нөлөөгөөр худалдааны салбар агшилттай байна.


- Уул уурхайн салбар 2025 онд 10.6 хувиар өслөө.
- Үүнд зэсийн баяжмал үйлдвэрлэл 2.1 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.
- Нүүрс олборлолт 95.5 сая тонн болж, өмнөх оноос 4 хувиар, алт олборлолт 13 тоннд хүрч 4 хувиар тус тус өссөн бол газрын тосны олборлолт 3.8 сая баррел болж 10.6 хувиар буурав.

- Хөдөө аж ахуйн салбар 2025 онд 33.2 хувиар өслөө.
- Цаг агаарын нөхцөл байдал харьцангуй тогтуун байж, бойжсон төлийн тоо толгой 21.7 саяд хүрч (төл бойжилт 96.5 хувь) өмнөх оны мөн үеэс 5.5 сая толгой малаар нэмэгдэн, том малын үеэ бус хоргодол өмнөх оны мөн үеэс 9 сая толгой малаар буурсны голлох нөлөөгөөр сүүлийн хоёр жил дараалан буурсан хөдөө аж ахуйн салбар сэргэв.




Өсөлтийг эрэлт талаас өрхийн хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлал болон бараа, үйлчилгээний экспорт дэмжлээ.

ДНБ-ий өсөлт
(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ТӨРИЙН БОЛОН ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН ӨСӨЛТ (жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Эдийн засгийн өсөлтийг дотоод эрэлт голлон дэмжив. Нийт өсөлтийн 6.6 нэгж хувийг өрхийн хэрэглээ, 3.3 нэгж хувийг үндсэн хөрөнгийн хуримтлал, 4.0 нэгж хувийг цэвэр экспорт бүрдүүлсэн байна.
- Харин эргэлтийн хөрөнгийн бууралт өсөлтийг 6.9 нэгж хувиар, төрийн хэрэглээ 1.3 нэгж хувиар бууруулсан байна.

- Төрийн хэрэглээ бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар буурсан бол өрхийн хэрэглээний өсөлт хадгалагдаж, 9.2 хувиар өслөө.


- Үндсэн хөрөнгийн хуримтлал 9.0 хувиар өсөхөд орон сууцны бус барилга байгууламжийн нөөц бодитоор 19.6 хувиар, орон сууцны барилга 29.1 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөллөө. Мөн өмнөх онд бууралттай байсан биологийн өсөж үрждэг хөрөнгө өсөлттэй гарч хөрөнгийн хуримтлалыг дэмжлээ.

- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 6.2 хувиар өссөн бол бараа, үйлчилгээний импорт үргэлжлэн саарч 1.1 хувиар агшсанаар цэвэр экспортод эерэг нөлөө үзүүлж байна.




Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 3 дугаар сард 61 хувиар өслөө. Уул уурхайн салбарт зэс, төмрийн хүдрийн олборлолтын биет хэмжээ өссөн нь голлон нөлөөлөв.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ (гэрбум төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

НҮҮРС ОЛБОРЛОЛТ (сая тонн)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ (голлох бүтээгдэхүүнээр)

Төрөл	Хэмжээ	Өмнөх оноос өөрчлөлт:
Зэсийн баяжмал	611 мян.тонн	36.3%
Газрын тос	887 мян. баррель	-8.2%
Алт	1.9 тонн	4.9%
Төмрийн хүдэр	1.4 сая.тонн	46.0%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2024=100)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2026 оны 3 дугаар сард 16.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 61 хувиар өслөө.
- Газрын тос болон бусад ашигт малтмалын үйлдвэрлэл буурсан ч нүүрс, металлын хүдэр олборлолт, уул уурхайн салбарын туслах үйл ажиллагаа өссөнөөр салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 74 хувиар өслөө.
- Ундаа болон хүнсний бүтээгдэхүүн, химийн бодис болон химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нөлөөгөөр боловсруулах салбар (нэрлэсэн дүнгээр) 2026 оны 3 дугаар сард 5.1 хувь өслөө.

- Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 80 орчим хувийг* уул уурхайн салбар, түүний дотор 40 орчим хувийг нүүрсний олборлолт эзэлдэг.
- Нүүрсний олборлолт 2026 оны 3 дугаар сард 28.7 сая тонн болж, өмнөх оноос 51.1 хувиар өслөө.

*2025 оны байдлаар

- 2026 оны 3 дугаар сард зэсийн баяжмалын үйлдвэрлэл 36.3 хувиар өсөж 611 мянган тоннд хүрэв.
- Төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэл 1.4 сая тоннд хүрч, 46.0 хувиар өссөн байна.
- Алт олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс 4.9 хувиар өсөж 1.9 тоннд хүрэв.
- Харин, газрын тос олборлолт 8.2 хувиар буурлаа.

- Үйлдвэрлэгчийн үнийн индекс 2026 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 16.7 хувиар өссөн байна.

Үнэ өссөн:

- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 13.6 хувиар;
- Ундаа үйлдвэрлэл 23.2 хувиар;
- Металлын хүдэр олборлолт 27.8 хувиар;

Үнэ буурсан:


- Нүүрс олборлолт 11.8 хувиар



Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны гуравдугаар сард бодит дүнгээр 5.8 хувиар буурав. Үүнд хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ундааны үйлдвэрлэл болон метал боловсруулах үйлдвэрлэл буурсан нь голлон нөлөөлсөн байна.

МАХ

(МЯН. ТОНН)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Боловсруулсан малын мах 2026 оны 3 дугаар сард 3.3 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 61 хувиар буурлаа.
- Боловсруулсан махны биет хэмжээ буурснаар боловсруулах салбарын 8-10 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэлийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оноос 28 хувиар буурлаа.

ГУРИЛ

(МЯН. ТОНН)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 3 дугаар сард 36.5 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар буурсан байна.
- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ буурч боловсруулах салбарын 5-7 орчим хувийг бүрдүүлдэг гурил болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний үйлдвэрлэл бодит дүнгээр (2024 оны суурьтай үйлдвэрлэлийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оноос 12 хувиар буурлаа.

УНДАА

(МЯН. ТОНН)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Согтууруулах болон согтууруулах бус ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 3 дугаар сард 115.6 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 14 хувиар буурлаа.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ буурсан ч боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг ундааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэлийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оноос 5 хувиар өссөн байна.

САМНАСАН НООЛУУР

(ТОНН)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


- Самнасан ноолуурын үйлдвэрлэл 2026 оны 3 дугаар сард 146 тонн болж, өмнөх оны мөн үеэс 57 хувиар өслөө.
- Ноолуурын үйлдвэрлэлийн биет хэмжээ өссөн ч боловсруулах салбарын 3-5 орчим хувийг бүрдүүлдэг ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэлийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оноос 8.5 хувиар бага байна.




Барилгын салбарын үйлдвэрлэлийн голлох орц болох цемент, вакум цонх болон хаалга, металл бэлдэц болон цувимлын үйлдвэрлэл нэмэгдсэн бол катодын зэсийн үйлдвэрлэл буурсан байна.




- Цемент үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 3 дугаар сард 172 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 95 хувиар өсөөд байна.



- Катодын зэс үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 3 дугаар сард 1,705 тонн болж, өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар буураад байна.



- Металл бэлдэц болон цувимал бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 3 дугаар сард 19 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар өсөөд байна.




- Вакум цонх, хаалганы үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 3 дугаар сард 9.4 мянган м.кв болж, өмнөх оны мөн үеэс 84 хувиар өслөө.



Нүүрсний тээвэр нэмэгдсэнээр тээврийн салбарын ачаа тээвэр нэмэгдлээ. Инфляцаар засварласан дүнгээр худалдаа, зочид буудал, нийтийн хоолны салбаруудын бодит орлого буурсан байна.

ХУДАЛДАА


(салбарын орлого, тэрбум төгрөг, ХҮИ-ээр засварласан бодит дүн)



Тэмдэглэл: Тус салбаруудын статистик нь 45 хоногийн хоцрогдолтой зарлагддаг.
Эх сурвалж: ЗЭХЯ-ны тооцоолол, ҮСХ

ЗОЧИД БУУДАЛ, ХООЛ

(салбарын орлого, тэрбум төгрөг, ХҮИ-ээр засварласан бодит дүн)



Тэмдэглэл: Тус салбаруудын статистик нь 45 хоногийн хоцрогдолтой зарлагддаг.
Эх сурвалж: ЗЭХЯ-ны тооцоолол, ҮСХ

ТЭЭВЭР

(тээсэн ачаа, сая тонн)


	2025.03	2026.03	ӨМНӨХ ОНООС:
Төмөр зам	10.3	15.1	46.5%
Уул уурхайн бүт.	7.5	11.5	53.3%
Агаар*	2.03	2.06	1.6%

	2024.IV	2025.IV	
Авто зам	87.8	96.5	9.9%
Уул уурхайн бүт.	60.0	64.4	7.3%

*мянган тонн
Тэмдэглэл: Авто замын тээврийн статистик улирлаар зарлагддаг.
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

(жуулчдын тоо, мянган хүн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар бүрдүүлдэг.
- Тус салбарын борлуулалтын орлого 2026 оны 2 дугаар сард нэрлэсэн дүнгээр 9.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар өссөн бол үнийн нөлөөг засварласан бодит дүнгээр 3.6 хувиар буурсан байна.

- 2026 оны 2 дугаар сард нэрлэсэн дүнгээр зочид буудлын салбарын борлуулалтын орлого 2.9 хувиар өссөн бол нийтийн хоолны салбарын борлуулалтын орлого 3.9 хувиар өссөн байна.
- Үнийн нөлөөг засварласан зочид буудлын салбарын бодит орлого 4.7 хувиар, нийтийн хоолны салбарын бодит орлогын дүн 3.7 хувиар тус тус буурсан байна.


- Төмөр замаар 2026 оны 3 дугаар сарын байдлаар 15.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 46.5 хувийн өсөлттэй байна.
- Агаараар тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үеэс 1.6 хувийн өсөлттэй байна.
- Авто замаар 2025 онд 96.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 9.9 хувийн өсөлттэй байна.

- 2026 оны эхний гурван сарын байдлаар Монгол Улсын хилээр орсон жуулчдын тоо 143.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 39.5 хувиар өссөн байна.



2026 оны 3 дугаар сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 7.4 тэрбум ам.долларт хүрсэн бол худалдааны тэнцэл 2.4 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.


ЭКСПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Экспорт 3 дугаар сард 4,889 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 62 хувиар өслөө.
- Нийт экспортын 95 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлээ.


ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспортын орлого 1,796 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 17 хувиар өслөө.
- Зэсийн баямжалын экспортын орлого 2,187 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 135 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 316 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 89 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 135 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5 хувиар өслөө.

ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- 2026 оны 3 дугаар сард импорт 2,477 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3 хувиар буурсан байна.
- Нийт импортын 24 хувийг нефтийн бүтээгдэхүүн, 17 хувийг тоног төхөөрөмж, 11 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 11 хувийг барилгын материал, 8 хувийг суудлын автомашин эзэлж байна.
- Ачааны тээврийн хэрэгслийн импорт 38 хувиар, суудлын автомашины импорт 37 хувиар, тоног төхөөрөмжийн импорт 8 хувиар, дизель түлшний импорт 1.4 хувиар буурсан нь нийт импорт буурахад нөлөөллөө.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар


- Нефтийн бүтээгдэхүүний импорт 586 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 13 хувиар өссөн байна.
- Тоног төхөөрөмжийн импорт 421 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8 хувиар буурсан байна.
- Суудлын автомашины импорт 206 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 37 хувиар буурлаа.
- Барилгын материалын импорт 267 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16 хувиар өссөн байна.
- Хүнсний импорт 266 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар өслөө.



2026 оны 3 дугаар сард уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 95 хувийг бүрдүүлээ.

НҮҮРС


(сая тонн)



- Нүүрсний экспортын биет хэмжээ 2026 оны 3 дугаар сард 27.5 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 57 хувиар өслөө.

ЗЭСИЙН БАЯМЖАЛ


(мян. тонн)



- Зэсийн баямжлын экспортын биет хэмжээ 2026 оны 3 дугаар сард 651 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 43 хувиар өслөө.

ТӨМРИЙН ХҮДЭР


(мян. тонн)



- Төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 2026 оны 3 дугаар сард 1,942 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 10 хувиар өслөө.

ГАЗРЫН ТОС

(мян. баррель)




- Газрын тосны экспортын биет хэмжээ 2026 оны 3 дугаар сард 861 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеийн түвшнээс 6 хувиар доогуур байна.




2026 оны 3 сард хөдөө аж ахуйн экспорт өмнөх оны мөн үеэс 21 хувиар нэмэгдлээ.


ХӨДӨӨ АЖ АХУЙН НИЙТ ЭКСПОРТ (сая ам.доллар)




ХОНЬ, ЯМААНЫ МАХ (сая ам.доллар)




САМНАСАН НООЛУУР (сая ам.доллар)




АРЬС, ШИР (сая ам.доллар)




БОЛОВСРУУЛСАН МАХ (сая ам.доллар)




АДУУ, ҮХРИЙН МАХ (сая ам.доллар)



УГААСАН НООЛУУР (сая ам.доллар)



НООС (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС

(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

ЗЭС

(\$/тонн , Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

ТӨМРИЙН БАЯЖМАЛ


(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламттай төмрийн баяжмал)



Эх сурвалж: Блүүмберг

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Brent)



Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2026 оны 3 дугаар сарын дундаж үнэ 221 ам.долларт хүрч, өмнөх сараас 9 хувиар, өмнөх оны мөн үеэс 24 хувиар буурсан байна.

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2026 оны 3 дугаар сарын дунджаар 12498 ам.доллар хүрч өмнөх оны мөн үеэс 28 хувиар өссөн байна.

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2026 оны 3 дугаар дундаж үнэ 106 ам.долларт хүрч, өмнөх сараас 4 хувиар, өмнөх оны мөн үеэс 4 хувиар өссөн байна.


- Бrent газрын тосны 2026 оны 3 дугаар сарын дундаж үнэ 94 ам.долларт хүрч өмнөх сараас 38 хувиар, өмнөх оны мөн үеэс 40 хувиар тус тус өслөө.



Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2026 оны 3 сард 6.2 сая тонн нүүрс, 1.3 сая тонн төмрийн хүдэр арилжаалаад байна.

НҮҮРСНИЙ АРИЛЖАА

(сая тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2026 оны 3 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 65.4 сая тонн нүүрс арилжиж, 6.7 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2025 онд 21.8 сая тонн нүүрс арилжиж, 1.6 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2026 оны эхний 3 сард 6.2 сая тонн нүүрс борлууллаа.

- 2026 оны 3 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 81 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 91 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 3 дугаар сард хэлцлийн доод үнэ 42 ам.доллар, дээд үнэ 155 ам.долларт хүрэв.

ТӨМРИЙН АРИЛЖАА

(мянган тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2026 оны 3 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 10.3 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 685 сая ам.долларын орлого олжээ
- Үүнээс 2025 онд 5.9 сая тонн төмрийг арилжаалж, 380 сая ам.долларын орлого олжээ.
- Харин 2026 оны эхний 3 сард 1.3 сая тонн төмрийн хүдэр борлууллаа.

ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)






Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- Төмрийн хүдэр болон баяжмалын 3 дугаар сарын дуудах дундаж үнэ 67 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 71 ам.доллар ам.доллар байв.
- Төмрийн төрлөөс хамааран 3 дугаар сард хэлцлийн доод үнэ 69 ам.доллар, дээд үнэ 85 ам.долларт хүрэв.



Төлбөрийн тэнцэл 2026 оны 2 дугаар сарын байдлаар 479 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2026 оны 3 дугаар сард өмнөх оноос 2.2 сая ам.доллороор өсөж, 7,188 сая ам.долларт хүрлээ.



- Төлбөрийн тэнцэл 2026 оны 2 дугаар сарын байдлаар 479 сая ам.долларын алдагдалтай байна.
- Урсгал дансны 320 сая ам.долларын ашигтай байгаа бол, санхүүгийн дансны 418 сая ам.долларын алдагдалтай байна.

- Гадаад валютын улсын нөөц 2026 оны 3 дугаар сарын эцэст 7,188 сая ам.доллар болж, өмнөх сараас 368 сая ам.доллар өссөн бол өмнөх оны мөн үеэс 2,192 сая ам.доллороор өслөө.

- Төгрөгийн ам.доллартой харьцаа ханш 2026 оны 3 дугаар сард өдөрт дунджаар 0.1 төгрөгөөр суларч, сарын эцэст 3,569 төгрөгт хүрлээ.

- Төв банк 2026 оны 3 дугаар сард 275 сая ам.долларыг зах зээлд нийлүүлээ.
- Төв банк 2026 оны эхний гурван сарын байдлаар мөн үеэс 731 сая ам.доллороор бага буюу нийт 1,171 сая ам.долларыг дуудлага худалдаагаар зах зээлд нийлүүлээд байна.


Тэмдэглэл: Төлбөрийн тэнцлийн статистик 1 сарын хоцрогдолтой зарлагддаг.



Инфляц 2026 оны 3 дугаар сард 7.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар буурлаа. Инфляц өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар буурахад цахилгааны тарифын суурь үеийн нөлөө арилсан болон тээврийн бүлгийн үнийн өсөлт саарсан нь голлон нөлөөллөө. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад 1.2 хувиар өссөн байна.

ЖИЛИЙН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

САРЫН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

СУУРЬ ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Инфляц 2026 оны 3 дугаар сард улсын хэмжээнд 7.4 хувь гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 1.9 нэгж хувь (25.9 хувь)-ийг бүрдүүлж байна. Сүүлийн сар импортын инфляц өсөхөд машины үнийн өсөлт нөлөөллөө.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 5.5 нэгж хувь буюу 74.1 хувийг эзэлж байна.

- 2026 оны 3 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.2 хувиар өслөө.
- Сарын инфляц 1.2 хувь гарахад махны үнэ өмнөх сараас 6.1 хувиар, суудлын автомашины үнэ 7.4 хувиар тус тус өссөн нь голлох нөлөөтэй байлаа.


- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2026 оны 3 дугаар сард суурь инфляц 5.1 хувь гарч, нийт инфляцын 3.1 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн сар өссөн үзүүлэлттэй байна.

- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт эрчимжсэнээр жилийн инфляцын 33 хувийг бүрдүүллээ.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар өслөө.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар өслөө.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 22.4 хувиар өслөө.



Олон улсад чингэлэг тээврийн үнэ 2,246 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 2 хувиар өслөө. Хүнсний үнийн индекс 2026 оны 3 дугаар сард өмнөх сараас 2.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ХҮНСНИЙ БА ХҮНСНИЙ БУС ИНФЛЯЦ (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Хүнсний инфляц 2026 оны 3 дугаар сард 14.1 хувь болж, нийт инфляцын 3.8 нэгж хувийг бүрдүүлэв. Хүнсний инфляц эрчимжихэд махны үнийн өсөлт нөлөөллөө.
- Хүнсний бус инфляц 4.8 хувьд хүрч, нийт инфляцын 3.6 нэгж хувийг бүрдүүллээ.


ИМПОРТЫН ИНФЛЯЦ БА ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2026 оны 3 дугаар сард дунджаар 3,567 төгрөг болж, өмнөх сараас 0.02 хувиар суларсан байна.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ 2026 оны 3 дугаар сард өмнөх сараас 1.2 хувиар өслөө. Үүнд суудлын автомашины үнэ өмнөх сартай харьцуулахад 7.4 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН ҮНЭ (1000\$ / 40 фут контейнер)



Эх сурвалж: Drewry World Container Index

- АНУ-ын тарифын бодлогоос үүдэлтэйгээр дэлхийн чингэлэг тээврийн үнэ өсөөд байсан бол 2025 оны 6 дугаар сараас эхлэн аажмаар буурч эхэллээ.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2026 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар 40 фут контейнер тутамд 2,246 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 2 хувиар өссөн бол өмнөх 7 хоногоос 3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- Чингэлэг тээврийн үнэ өсөж байгаа нь нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна.

ХҮНСНИЙ ҮНИЙН ИНДЕКС (хувь)



Эх сурвалж: FAO


- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2026 оны 3 дугаар сард 128.5 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.0 хувиар, өмнөх сараас 2.4 хувиар тус тус өссөн байна.
- Сүүлийн сар дэлхийн зах зээл дээр үр тариа, мах, ургамлын тос, сүүн бүтээгдэхүүн, элсэн чихрийн үнэ бүгд өссөн байна. Үүнд дэлхийн зах зээл дээр эрчим хүчний үнэ өссөн нь нөлөөлжээ.



Нэгдсэн төсвийн орлого 2026 оны 3 дугаар сарын байдлаар 7,196.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар, зарлага 7,663.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 17.9 хувиар өслөө.

ТӨСВИЙН ОРЛОГО


(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ТАТВАРЫН ОРЛОГО


(татварын төрлүүдээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ТӨСВИЙН ЗАРДАЛ

(зардлын ангиллаар, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

УРСГАЛ ЗАРДАЛ

(зардлын ангиллаар, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2026 оны 3 дугаар сарын байдлаар 6.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 153.0 тэрбум төгрөг буюу 2.5 хувиар өссөн байна.
- Татварын орлого 2026 оны эхний 3 сард 5.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 75 тэрбум төгрөг буюу 1.3 хувиар өсөхөд НД болон НӨАТ-ын орлогын өсөлт нөлөөллөө.
- Харин ААНОАТ-н орлого өмнөх оны мөн үеэс 418.8 тэрбум төгрөгөөр (30.3 хувь) буурсан байна.

- Төсвийн нийт орлогын өсөлтөд АМНАТ 1.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 601.4 тэрбум төгрөг буюу 94.6 хувиар, НД-ын орлого 1.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 225.5 тэрбум төгрөг 19.0 хувиар, НӨАТ 1.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 159.7 тэрбум төгрөг буюу 12.8 хувиар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

- Нэгдсэн төсвийн зарлага 2026 оны 3 дугаар сард 7.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд төгрөг буюу 17.9 хувиар өссөн байна.
- Нийт өсөлтийн 10.2 нэгж хувийг урсгал зардлын өсөлт, 7.7 нэгж хувийг хөрөнгийн зардлын өсөлт тайлбарлаж байна.
- Хөрөнгийн зардал 1.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 497.5 тэрбум төгрөг буюу 84.0 хувиар өсөхөд барилга байгууламжийн зардлын өсөлт голлон нөлөөлсөн байна.


- Урсгал зардлын өсөлтөд цалингийн зардал 1.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 295.8 тэрбум төгрөг буюу 19.6 хувиар, тэтгэвэр, тэтгэмжийн нийт зардал 2.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 273.5 тэрбум төгрөг буюу 13.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.
- Харин засгийн газрын урсгал шилжүүлэг 736.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 58.4 тэрбум төгрөг буюу 7.3 хувиар, нэмэгдэл, урамшууллын зардал 384.8 тэрбум төгрөгт хүрч, 41.6 тэрбум төгрөг буюу 10.8 хувиар тус тус буурчээ.



Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2026 оны 3 дугаар сарын байдлаар 1,360.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ


(Их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

(Их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(Зүүн тэнхлэг: их наяд төгрөг
Баруун тэнхлэг: ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Сангийн яам

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(Их наяд төгрөг)

	2024.IV	2025.IV	Өсөлт/бууралт
Засгийн газрын нийт өр	33.4	35.4	5.9%
ДНБ-д эзлэх хувь	42.4%	39.4%	
Засгийн газрын дотоод өр	0.4	0.7	75%
Засгийн газрын гадаад өр	30.3	32.1	5.9%
Үнэт цаас	8.7	9.0	3.4%
Зээл	21.6	23.1	6.9%
Засгийн газрын бусад өр	2.7	2.7	
ЗГ өрийн баталгаа	0.2	0.2	
Нийслэлийн үнэт цаас	2.6	2.5	(3.8)%

Эх сурвалж: Сангийн яам

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2026 оны 3 дугаар сарын байдлаар 1.4 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарахад төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэврийг нэмэгдүүлсэн нь голлох нөлөө үзүүллээ.

- Нэгдсэн төсвийн нийт тэнцэл 2026 оны 3 дугаар сарын байдлаар 466.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс төсвийн алдагдал 396.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Төсвийн үндсэн тэнцэл нь хүүгийн зардлыг хасаж тооцсон тэнцэл бөгөөд 2026 оны 3 дугаар сард 30.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.
- Энэ нь хүүгийн төлбөрийг эс тооцвол төсвийн суурь үйл ажиллагаа алдагдалтай гарсныг илэрхийлж байна.


- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 35.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар өсөж, ДНБ-ий 39.4 хувьд хүрсэн байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.

- Засгийн газрын нийт өрийн 90 хувийг гадаад өр, үүний дотор 72 хувийг гадаад зээл, үлдсэн 28 хувийг гадаад үнэт цаас бүрдүүлж байна.
- Нийт өрийн бүтцэд гадаад өр давамгайлж байгаа нь валютын ханшийн хэлбэлзэл, олон улсын зах зээлийн нөхцөл байдал, хүүгийн түвшний өөрчлөлтөөс шууд хамаарах тул өрийн эрсдэл харьцангуй өндөр байгааг илэрхийлж байна.



Мөнгөний нийлүүлэлт 2026 оны 3 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 21.3 хувиар өсөж, 49.4 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2026 оны 3 дугаар сард 45.0 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 16.6 хувьд хүрлээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж: Монголбанк

ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж: Монголбанк

ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (хувь)



Эх сурвалж: Монголбанк

ХҮҮГИЙН ТҮВШИН (жигнэсэн дундаж хувь)




Эх сурвалж: Монголбанк

- Мөнгөний нийлүүлэлт 2026 оны 3 дугаар сарын эцэст 49.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 21.3 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 12.0 нэгж хувь, гадаад валютын хадгаламж ба харилцах 7.1 нэгж хувь, төгрөгийн харилцах 2.1 нэгж хувь, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.1 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.
- Нийт хадгаламж 32.5 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 20.2 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 27.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 22.1 хувиар өслөө.
- Гадаад валютын хадгаламж 5.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар өслөө.
- Банкнүүдэн зээлийн үлдэгдэл 2026 оны 3 дугаар сарын эцэст 45.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.1 хувь буюу өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар буурлаа.
- Банкнүүдэн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2026 оны 3 дугаар сард 17.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар, өмнөх сараас 0.3 нэгж хувиар тус тус өссөн байна.
- Банкнүүдэн шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2026 оны 3 дугаар сард 11.8 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өссөн бол өмнөх сараас өөрчлөлтгүй байна.



Ажиллагчдын тоо 1 сая 384 мянгад хүрсэн ч өсөлтийн хурд саарч, ажилгүй иргэдийн өсөлтийн нөлөөгөөр ажиллах хүчний өсөлт нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 62.3 хувь болж өслөө.

АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ХҮЙСЭЭР (мянган хүн, хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, САЛБАРААР (мянган хүн)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ДУНДАЖ ЦАЛИН, ГОЛЧ ЦАЛИН, БОДИТ ЦАЛИН (мянган төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 30 мянга буюу 2.2 хувиар нэмэгдэж 1 сая 384 мянгад хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 195 мянгаар өндөр үзүүлэлт болов.
- 2025 оны 4 дүгээр улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 14 мянгаар, эмэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 16 мянгаар тус тус өссөн байна.

- Ажиллагчдын тооны өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын сэргэлтийн нөлөөгөөр ажиллагчдын тоо 30 мянгаар нэмэгдсэн. Түүнчлэн уул уурхай, боловсруулах, барилгын салбарын ажиллагчид нэмэгдсэн нь нийт ажиллагчдын өсөлтийг дэмжсэн байна.
- Харин цахилгаан, ус, тээвэр, худалдааны салбарын ажилчдын тоо буурсан нь сөргөөр нөлөөллөө.



- Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 7.3 мянгаар өссөнөөр ажилгүйдлийн түвшин 5.6 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өссөн байна.
- Харин ажиллах хүчний оролцооны түвшин ажиллагчид болон ажилгүй иргэдийн өсөлтийн нөлөөгөөр өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өсөж 62.3 хувьд хүрээд байна.

- Дундаж цалингийн хэмжээ 2026 оны 3 дугаар сарын байдлаар 2 сая 856 мянган төгрөг байна.
- Улсын голч цалин 2 сая 496 мянган төгрөг (дундаж цалингаас 360 мянган төгрөгөөр бага) байна. Энэ нь ажилчдын талаас илүү нь 2.5 сая төгрөгөөс бага цалин авч байгааг илэрхийлж байна.
- Хэрэглээний үнийн индексээр засварлагдсан бодит цалин 2 сая 339 мянган төгрөгт хүрлээ.

(Энд ХҮИ 2023=100)



Өрхийн бодит орлого 5 хувиар өслөө.



- Өрхийн бодит орлогын өсөлтийн эрчим өмнөх улирлаас сайжирч, 5.0 хувиар өсөв.
- Өрхийн орлогын өсөлтөд иргэдийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс нэрлэсэн дүнгээр 210.4 мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 29.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

- Өрхийн орлого, зарлагын өсөлт тэнцвэржиж, иргэдийн хадгаламжийн өсөлт үргэлжлэн удааширсаар байна.

- Бага орлоготой өрхийн орлого төдийлөн өсөлтгүй хэвээр байна.
- Нийт өрхийн 29.1 хувийг бүрдүүлж буй 1.6 сая төгрөгөөс бага орлоготой өрхүүдийн сарын дундаж нэрлэсэн орлого 970 мянган төгрөгт хүрч өмнөх улирлаас 21.3 мянган төгрөгөөр, 1.6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого 3.6 сая төгрөгт хүрч, өмнөх улирлынхаас 63 мянган төгрөгөөр тус тус өслөө.

- Хөдөөгийн өрхийн бодит орлогын өсөлт Улаанбаатар болон улсын дундажаас өндөр хэвээр хадгалагдаж байна.
- Үүнд 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хөдөө суманд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг үндсэн цалингийн 40 хувиар тооцож нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлжээ.



Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2026 оны 1 дүгээр улиралд 268.3 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 367 аар буюу 0.1 хувиар буурлаа.

НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААН-ИЙН ТОО

(мянга, үйл ажиллагаа эрхлэлтээр)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2026 оны 1 дүгээр улиралд 268.3 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 367 оор буурлаа.
- Үйл ажиллагаа явуулж буй болон үйл ажиллагаа эхлээгүй ААН-үүд өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар нэмэгдсэн бол, үйл ажиллагаа зогсоосон болон олдохгүй байгаа аж ахуйн нэгжүүд 10.9 хувиар буурсан байна.
- Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо буурсан хэдий ч идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж буй нь эдийн засгийн идэвхжилттэй байгааг харуулж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

(ААН-ийн тоо, салбараар)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо худалдааны салбарт 2.2 мянга, үйлчилгээний салбарт 2.1 мянгаар нэмэгдлээ.
- Мөн хөдөө аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлсэн зэрэгтэй холбоотойгоор тус салбарын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 13 хувиар өссөн байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТОО

(мянга, ажиллагчдын тоогоор)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Үйл ажиллагаа явуулж буй 117.3 мянган ААН-ийн 102.0 мянга нь бичил буюу 1-9 ажилтантай ААН-үүд байна.
- Мөн 1-9 ажилтантай ААН-үүдийн өсөдөг үйл ажиллагаа явуулж буй нийт ААН-ийн өсөлтийг бүрдүүлж байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС

(улирлаар, 2018=100)






Эх сурвалж: Үндэсний судалгаа зөвлөлийн төв (Эн-Ар-Си-Си ХХК)

- Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 2025 оны 4 дүгээр улиралд 91.9 болж өмнөх оны мөн үеэс 12.8 нэгжээр муудлаа.
- ХИИ-ийг задлан харвал хэрэглэгчдийн эдийн засгийн одоогийн нөхцөлийн үнэлэмжийг харуулдаг Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 14.0 нэгжээр буурсан.
- Мөн эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлтийг харуулдаг Ирээдүйн хүлээлтийн индекс 5.1 нэгжээр буурсан бөгөөд үүнд бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлогын хүлээлт муудсан нь нөлөөллөө.



ОХУ-ын эдийн засаг 2025 оны 4 дүгээр улиралд 1 хувиар өслөө. Инфляцын түвшин 2026 оны 2 дугаар сард 5.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 4.2 нэгж хувиар буурсан байна.




- ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2025 оны 4 дүгээр улиралд 1.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар буурлаа.
- 2026 оны 2 дугаар сарын байдлаар экспорт 30.1 тэрбум ам.доллар, импорт 24.8 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 5.4 тэрбум ам.долларын ашигтай байна.
- Экспорт 2026 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 5 хувиар буурлаа.
- Импорт 2026 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 20 хувиар өслөө.
- ОХУ-ын инфляц зорилтот түвшин болох 4 хувиас өндөр хэвээр байна.
- Инфляцын түвшин 2026 оны 2 дугаар сард 5.9 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 4.2 нэгж хувиар буурсан байна.
- Жилийн инфляцын түвшин 2025 онд 8.7 хувьд хүрч, өмнөх оноос 0.3 нэгж хувиар өслөө.
- ОХУ-ын төв банкнаас 3 дугаар сарын 20-ны өдөр бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулж, 15.0 хувьд хүргэх шийдвэр гаргасан.
- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2026 оны 3 дугаар сард 48.3 болж, өмнөх сараас 1.2 нэгжээр буурлаа.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2026 оны 2 дугаар сарын байдлаар -0.9 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурлаа.



Хэдийгээр дотоод эрэлт сул хэвээр байгаа ч экспорт, дотоодын эрэлт нэмэгдсэнээр БНХАУ-ын эдийн засаг 2026 оны эхний улиралд 5.0 хувиар өслөө.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(хувь)



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- БНХАУ-ын эдийн засаг 2026 оны эхний улиралд 5.0 хувиар өслөө.
- 2026 оны 3 дугаар сард экспорт 2.5 хувиар, импорт 27.8 хувиар тус тус өсөж өмнөх сараас чангарсан үзүүлэлттэй байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.

АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ

(хувь)




Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн гарц 2026 оны 3 дугаар сард 5.7 хувиар өсөж, өмнөх сараас өсөлт саарлаа.
- Хэрэглээний төлөвийг илэрхийлэх жижиглэн худалдааны борлуулалт 2026 оны 3 дугаар сард 1.7 хувь болж эрчимжсэн байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.

ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Блүүмберг

- Хэрэглээний үнийн индекс 2026 оны 3 дугаар сард 1.0 хувь гарч дефляцийн бүсээс гарлаа.
- Үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2026 оны 3 дугаар сард 0.5 хувь гарч, үнийн уналтын бүсээс гарлаа.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) (нэгж)



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2026 оны 3 дугаар сард 50.4 болж, тэлэлтийг илэрхийлж байна.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас өсөж 50 түвшинд байна.

Тэмдэглэл: Тус индекс нь богино хугацааны идэвхилийг илэрхийлэх бөгөөд ААН-үдийн худалдан авалт, үйлдвэрлэл, амжилттай, түүний эдийн нөөц зээг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ